



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын 5 дугаар багийн Ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/109/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Л.Равдандорж Утас: 70523020 Цахим хаяг: ravdandorjl@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Ауд. 02. 22 № 1-6/63

танай _____ -ны № _____ -т

САЙНШАНД СУМЫН 5 ДУГААР БАГИЙН
ЗАСАГ ДАРГА Ч.БАДАМЛЯНХУА
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын 5 дугаар багийн Ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сайншанд сумын 5 дугаар багийн Ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Шилэн дансны мэдээллийн цахим системд мэдээллийг бүрэн байршуулдаггүй, хоосон баталгаажуулдаг, хөрөнгө зарцуулах тухай тушаал, шийдвэрүүдийг мэдээлдэггүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйл 5.5-т "Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна", 6 дугаар зүйл 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг тус тус зөрчсөн, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад-1, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Байгууллагын архивын өрөө тохижуулах ажилд Доншен газрын тос монгоиа ХХК-с 1 000 000 /нэг сая/ төгрөгийн хандив, тусламжийг авч зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйл 25.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1 "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад-1, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлснөөс хөдөлмөрийн чадвараа хагас болон хэсэгчлэн алдсан 2 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тогтоосон хувь хэмжээнээс нь илүү суутгасан, урьдчилж бодогдсон ээлжийн амралтын тооцоог давхар хийж илүү суутгасан зэрэг алдаа зөрчлүүд байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох ...", Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.6-д "....тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна....." гэж заасныг тус тус зөрчсөн, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад-1, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Ажилчидтай холбогдолтой тогтоогдсон төлбөрийн актыг байгууллагын цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас гарган барагдуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тогтоолоор батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад-1, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
5. Бараа материалын тайлан гаргаагүй, анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад-1, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу илэрхийллийн түвшнийг 6.0 сая төгрөгөөр тогтоосон. Илэрсэн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг буруу илэрхийллийн түвшнээс 0.6 сая төгрөгөөр давсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3.6	5.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	632.3	590.8
	Нийт хөрөнгийн дүн	635.9	595.8
	Нийт өр төлбөрийн дүн	1.7	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	634.2	595.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	635.9	595.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	231.3	194.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	212.0	215.4
	Үйл ажиллагааны үр дүн	19.3	-20.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	-17.7
	Үйл ажиллагааны нийт үр дүн	19.3	-38.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	634.2	595.8
	Тайлант оны үр дүн	19.3	-38.5
	Эцсийн үлдэгдэл	634.2	595.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	180.6	186.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	178.7	186.2
	Үйл ажиллагааны ЦМГ	1.9	0.7
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-1.9	-0.7
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	177.1	183.1
	Урсгал зардал	177.1	183.1
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	177.1	183.1
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	177.1	183.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.0	0.0

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилго: Хууль дээдлэх, төрийн албаны шуурхай, тасралтгүй, чанартай байх зарчмыг чанд баримтлан, хууль журмыг сахин биелүүлж, иргэн бүрд хүнд сурталгүй төрийн үйлчилгээг бүргэж, багийн хэмжээнд төрийн байгууллагын манлайллыг хангана.

Байгууллагын зорилт: Төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх.

Сайншанд сумын 5-р багийн Ажлын алба нь нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээ хүргэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар онцлох зүйл гараагүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Сайншанд сумын 5-р багийн Ажлын алба нь эд хариуцагчийн тайлан, мэдээ гаргадаггүй, эрх бүхий албан тушаалтны цохолт, зөвшөөрлийг авч бараа, материалыг зарцуулаагүй алдаа зөрчил их байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 132, оруулаагүй 17 мэдээлэл байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа, материалын тайлан, анхан шатны баримтын бүрдлийг авч үзэх.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 92.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 85.7 сая төгрөгийн алдааг залруулж, 0.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

7.1 Залруулсан алдаа

1. Үр дүнгийн тайлан өмнөх үеийн үзүүлэлтээс 71.1 сая төгрөгөөр зөрүүлэн тайлагнасан.
2. Үндсэн хөрөнгийн дансанд 6 ширхэг хөрөнгөнд 0.2 сая төгрөгийн элэгдлийг илүү байгуулсан.
3. Урьдчилгаа цалингийн 14.5 сая төгрөгийн бичилтийг алдаатай хийсэн.

7.2 Албан шаардлага

1. Шилэн дансны мэдээллийн цахим системд мэдээллийг бүрэн байршуулдаггүй, хоосон баталгаажуулдаг, хөрөнгө зарцуулах тухай тушаал, шийдвэрүүдийг мэдээлдэггүй.
2. Архивын өрөө тохижуулах ажилд Доншен газрын тос монгоиа ХХК-с 1.0 сая төгрөгийн хандив, тусламжийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй авч зарцуулсан.
3. Ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлснөөс 0.1 сая төгрөгийн илүү суутгал хийсэн.

7.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 33 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “...ашиглах хугацаа нь дууссан эд хөрөнгийг... акт тогтоон устгаж болно”, 31.3.2-т “...элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нь нөхсөн ... эд хөрөнгийн үнийг ...зөвшилцөн тогтооно” гэж заасныг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Ашиглах боломжтой боловч ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг үнэлж бүртгэх, шаардлага хангаагүй хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ авч ажиллах.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Бараа материалын тайлан гаргаагүй, анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна

2.2. Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайлан мэдээг холбогдох заавар, аргачлалын дагуу хөтөлж, анхан шатны баримтаар нотлогдсон ажил, гүйлгээг тайлан мэдээнд тусгаж байх.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	9	92.3	3	85.7	1	0.1	3	1.1	2	5.4
	НИЙТ	9	92.3	3	85.7	1	0.1	3	1.1	2	5.4